Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,620.1 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 28,127.9 | 48,301.3 | (20,173.3) |
| Авлага | 25.1 | 8,512.8 | (8,487.6) |
| Бараа материал | 68,569.2 | 55,325.1 | 13,244.1 |
| Үндсэн хөрөнгө | 520,739.4 | 520,942.6 | (203.2) |
| **Нийт хөрөнгө** | **617,461.8** | **633,081.9** | **(15,620.1)** |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 617,461.8 | 633,081.9 | 15,620.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **617,461.8** | **633,081.9** | **15,620.1** |

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 20,3173.3 мянган төгрөгөөр өссөн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт оны эцэст хийгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 8,512.8 мянган төгрөг болж 8,487.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагын дүн байна.

Бараа материал дансны эм боох материал 8,305.6 мянган төгрөг, аж ахуйн материал 7,930.9 мянган төгрөг, бичиг хэргийн материал 89.4 мянган төгрөг, хүнсний материал 555.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан 8,392.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 12,173.9 мянган төгрөгийн эм боох материал, 210.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал хүлээн авснаас нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд тоног төхөөрөмж 40,650.3 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,162.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 9,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,162.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 31,550.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авснаар үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 633,081.9 мянган төгрөг болж 15,620.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 455,329.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төв нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 28.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 455,357.6 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 427,191.5 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 28,166.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 28.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 427,191.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 28,166.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Тайлант оны батлагдсан төсөв 455,329.4 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 427,778.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 427,778.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 210,224.5 мянган төгрөг буюу 83.2 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | 71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 1.1 | 80111-Төрийн байгууллагуудын тогтмол зардал | 28,166.1 | 23,006.6 | 5,159.5 | 81.7 |
| 1.2 | 80302-Нэг хүнд ногдох нормативаар тооцсон. | 272,006.3 | 305,256.2 | (33,249.9) | 112.2 |
| 1.3 | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 147,225.0 | 52,571.8 | 94,653.2 | 35.7 |
| 1.4 | 83603- Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 28,127.9 | 21,410.8 | 6,717.1 | 76.1 |
| | **Дүн** | **455,357.6** | **402,245.4** | **73,279.9** | **83.2** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төв нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 103,263.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Үүнээс тээвэр шатахуун, бичиг хэрэг, ашиглалтын зардал, шуудан холбоо, урсгал засвар, багаж техник, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал нийт 12 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн. Үүнээс 69,546.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг цахим худалдан авалтаар хийхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр хоол хүнс 116,992.8 мянган төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авсан байна. Худалдан авалтын дүн өссөн нь үнэ нэмэгдсэнтэй холбоотой.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж,чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 11/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн батлагдсан 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 525,571.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,883.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,912.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус эмнэлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гаргаагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна. Үнд:, Норматив зардал 6,668.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 510.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 4,582.3 мянган төгрөг, нийт 11,760.8 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс, 2 мэдээ хугацаа болоогүй, 146 мэдээллийг хуулийн хугацаанд, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 9 харилцагчтай холбоотой 85,088.6 мянган төгрөгийн орлогын мэдээг хуулийн хугацаанд ил тод байршуулаагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансанд байршуулах мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хуулийн хугацаанд багтаан мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 акт өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 11/35 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 268.7 | 1 | 268.7 | 100% |
| Албан шаардлага | 1 | 341,449.7 | 1 | 341,449.7 | 100% |
| Зөвлөмж | 3 | 4,004.6 | 3 | 4,004.6 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **345,723.0** | **5** | **345,723.0** | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Залруулсан алдаа**

Аудитаар нийт 500,453.1 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулллаа.Үүнд:

1.Мөнгөн гүйлгээний тайланд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 427,191.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан. Энэ нь УСНББОУС 1-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандартын заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг 73,261.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 6,896.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс,1,418.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 5,477.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1.Анхан шатны баримтыг бүрдүүлэлт дутуу, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийсэн 1,418.7 мянган төгрөгийн зөрчил нь, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д " нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг," гэж заасантай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

2. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүллээ.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ"; Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Түлш шатахууны тайлан бэлтгэхдээ жолооч нартай спидометрийн заалтаар шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоо бодоогүй 5,477.4 мянган төгрөг байна. УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглох. Зам тээврийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал.

Өгсөн зөвлөмж: Түлш шатахууны тооцоог сар тутам тооцон, тооцоог бодож хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| /Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого дутуу тусгасан | 1 | 427,191.5 | 1 | 427,191.5 | | | 1 | 427,191.5 | | | | |
| Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 73,261.6 | | | 1 | 73,261.6 | 1 | 73,261.6 | | | | |
| **Дүн** | **2** | **500,453.1** | **1** | **427,191.5** | **1** | **73,261.6** | **2** | **500,453.1** | | | | |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Түлш шатахууны тайлан бэлтгэхдээ жолооч нартай спидометрийн заалтаар шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоо бодоогүй | 1 | 5,477.4 | | | | | 1 | 5,477.4 | | | | |
| Анхан шатны баримтыг бүрдүүлэлт дутуу, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийсэн | 1 | 1,418.7 | | | 1 | 1,418.7 | | | | | | |
| Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгээгүй | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| **Дүн** | **3** | **6,896.1** | | | **1** | **1,418.7** | **1** | **5,477.4** | **1** | **-** | | |

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээлбэл зохих орлогын мэдээг ил тод байршуулаагүй, 11 мэдээг хугацаа хоцроон байршуулсан. | 9 | 85,088.6 | | | 9 | 85,088.6 | | |
| **Дүн** | **9** | **85,088.6** | | | **9** | **85,088.6** | | |

# ТӨВ АЙМАГ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр Дугаар 102-17225502-ТӨА-2024/175/НА-СТА-ТШ3 Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,418,740.00 төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д " нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалт хийсэн цаг тухайд нь НӨАТ-ын баримтад бүртгүүлж сар бүрийн 10-ны дотор бэлтгэн нийлүүлэгчтэй НӨАТ-ын тулгалт хийх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040361

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Отгонбаяр, нягтлан бодогч Б.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ

**ТӨВ АЙМАГ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 05 сарын 27 өдөр    Дугаар 103-17225502-ТӨА-2024/175/НА-СТА-ТШЗ    Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 9 харилцагчтай холбоотой 85,088,560.68 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй, 11 мэдээг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.2-д.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх; 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

---

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040364

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Отгонбаяр, нягтлан бодогч Б.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ

**ТӨВ АЙМАГ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 03 сарын 27 өдөр Дугаар 95-17225502-ТӨА-2024/175/НА-СТА-ТШЗ Зуунмод

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Б.Байгалмаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

---

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

0190441?

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баян сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Отгонбаяр, нягтлан бодогч Б.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ